ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Монгол цэргийн музей УТҮГ 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/234/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Хэлтсийн дарга: Б.Лхагвацэнд<br>Утас: 51-261885 Цахим хаяг: Lkhagvatsendb@audit.gov.mn<br>Аудитор: Ч.Дашдаваа<br>Утас: 51-263533 Цахим хаяг: Dashdavaach@audit.gov.mn<br>Аудитыг гүйцэтгэсэн: Голден пэйж Аудит ХХК<br>Захирал: С.Оюунгэрэл<br>Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/741
танай ______________-ны №______________-т

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙ УТҮГ
ДАРГА Д.ГАНЗОРИГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол цэргийн музейн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол цэргийн музейн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Батлан хамгаалахын сайдын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Соёлын биет өвүүдийг шилжүүлэх тухай А/135 дугаар тушаалаар Чингис хаан музейд 66,522,500.00 (жаран зургаан сая таван зуун хорин хоёр мянга таван зуун) төгрөгийн үнэ бүхий соёлын биет өвүүдийг шилжүүлэх шийдвэр гарсан боловч 2024 онд 22,687,500.00 (Хорин хоёр сая зургаан зуун наян долоон мянга таван зуун) төгрөгийн үнэтэй Хотгор илд 1 ширхгийг балансаас балансад шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Монгол цэргийн музей нь музейн сан хөмрөг хадгалагдаж байгаа 13 төрлийн сан хөмрөг 3786 дэсийн 9947 үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлийг Сангийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаалаар батлагдсан "Түүх соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам"-ын дагуу бүртгэсэн байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-78.Docx

1525070326

**Бусад асуудлын хэсэг**

Бид аудитыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС), Монгол Улсын Төрийн Аудитын тухай хууль болон Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан гарын авлага, холбогдох заавар журмын дагуу явуулна. Иймд Аудитор нь санхүүгийн тайланг материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн хангалттай нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж, гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн гүйцэтгэнэ. Аудитын үед санхүүгийн тайлан болон нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалт хийсний үндсэн дээр олж авдаг. Аудитор нь байгууллагын бүртгэлтэй холбоотойгоор удирдлагын хэрэглэж буй бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн томоохон гэрээ, тооцооллууд, түүнчлэн санхүүгийн тайлагналын байдалд бүхэлд нь дүгнэлт өгнө.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **83,537,043.38** | **94,205,745.06** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **83,537,043.38** | **94,205,745.06** |
| **351** | **Түүхий эд материал** | **68,000.00** | **68,000.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 68,000.00 | 68,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **83,469,043.38** | **94,137,745.06** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,817,163.00 | 3,193,851.68 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,624,137.00 | 2,365,900.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 10,484,210.00 | 10,962,960.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 68,543,533.38 | 77,615,033.38 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,024,852,855.31** | **4,909,343,774.43** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,024,852,855.31 | 4,909,343,774.43 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,994,941,645.46 | 4,879,467,564.62 |
| 39201 | Барилга, байгууламж | 3,671,307,527.40 | 3,671,307,527.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -532,275,844.32 | -638,692,429.08 |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 206,427,384.44 | 219,533,664.78 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -103,929,103.10 | -105,893,764.86 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 107,797,069.93 | 115,750,389.93 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -77,867,622.48 | -83,638,557.14 |
| 39213 | Түүх соёлын дурсгалт зүйлс | 1,716,393,514.64 | 1,694,012,014.64 |
| 39217 | Номын фонд | 7,088,718.95 | 7,088,718.95 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 29,911,209.85 | 29,876,209.81 |
| 39301 | Програм хангамж | 1,120,000.00 | 1,120,000.00 |
| 39302 | Хасагдуулга | -901,250.15 | -936,250.19 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 29,692,460.00 | 29,692,460.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,108,389,898.69** | **5,003,549,519.49** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **5,108,389,898.69** | **5,003,549,519.49** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,108,389,898.69 | 5,003,549,519.49 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 1,239,669,238.14 | 1,239,669,238.14 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 1,239,669,238.14 | 1,239,669,238.14 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -691,183,972.23 | -796,024,351.43 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 640,593,252.18 | -691,183,972.23 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -50,590,720,05 | -104,840,379.20 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,559,904,632.78 | 4,559,904,632.78 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **5,108,389,898.69** | **5,003,549,519.49** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **835,227,235.20** | **1,165,597,503.67** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **112,221,394.20** | **57,228,203.67** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 111,271,394.20 | 57,228,203.67 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 111,271,394.20 | 57,228,203.67 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,974,300.00 | 15,994,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 706,300.00 | 318,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 97,590,794.20 | 40,916,103.67 |
| **122** | **Тусламжийн орлого** | 950,000.00 | - |
| 132001 | Хандив тусламж /дотоод/ | 950,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **723,005,841.00** | **1,108,369,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **681,503,400.00** | **1,073,582,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 681,503,400.00 | 1,073,582,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 41,502,441.00 | 34,786,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 2,228,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 39,274,441.00 | 34,786,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **862,979,691.25** | **1,223,053,582.87** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **862,979,691.25** | **1,223,053,582.87** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 847,095,661.25 | 1,178,663,214.87 |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 578,983,224.00 | 886,272,100.00 |
| 210101 | Цалин | 366,192,623.00 | 478,126,800.00 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 177,984,200.00 | 278,107,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,115,800.00 | 52,401,100.00 |
| 210104 | Урамшуулал | 22,690,601.00 | 56,705,700.00 |
| 210105 | Гэрээтийн цалин | - | 20,931,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,699,146.00 | 88,568,474.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 44,066,145.00 | 61,605,613.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5,183,295.00 | 7,419,021.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,146,636.00 | 3,772,094.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 861,334.01 | 2,764,842.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 10,441,736.00 | 13,006,904.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,093,853.00 | 43,774,500.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 8,140,458.00 | 11,848,853.51 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 19,644,533.00 | 28,208,791.49 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 2,308,862.00 | 3,716,855.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,005,277.00 | 11,040,284.99 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 1,831,627.00 | 5,111,974.99 |
| 210403 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 889,750.00 | 976,800.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1,283,900.00 | 2,678,400.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | - | 713,680.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 226,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 1,332,830.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативд зардал** | - | 3,888,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 3,888,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,462,338.90 | 12,336,675.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,462,338.90 | 12,336,675.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | 32,051,788.00 | 13,509,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,810,288.00 | 11,408,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | - | 2,101,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 241,500.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 126,800,034.35 | 119,273,680.88 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 126,800,034.35 | 119,273,680.88 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15,884,030.00 | 44,390,368.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,999,800.00 | 21,532,804.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 11,191,404.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,999,800.00 | 10,341,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 13,884,230.00 | 22,857,564.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,884,230.00 | 22,857,564.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **-27,752,456.05** | **-57,456,079.20** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | 22,838,264.00 | 47,384,300.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 22,838,264.00 | 47,384,300.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | -22,838,264.00 | -47,384,300.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **-50,590,720.05** | **-104,840,379.20** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **736,686,441.00** | **1,124,681,400.00** |
| **77** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,680,600.00** | **16,312,100.00** |
| **78** | **Нийтлэг татварын бус орлого** | 13,680,600.00 | 16,312,100.00 |
| **82** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | 13,680,600.00 | 16,312,100.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,974,300.00 | 15,994,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 706,300.00 | 318,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **723,005,841.00** | **1,108,369,300.00** |
| | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 681,503,400.00 | 1,073,582,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 681,503,400.00 | 1,073,582,900.00 |
| | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 41,502,441.00 | 34,786,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,228,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 39,274,441.00 | 34,786,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **736,686,441.00** | **1,114,754,100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **736,686,441.00** | **1,114,754,100.00** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **720,802,411.00** | **1,070,363,732.00** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 578,983,224.00 | 886,272,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 366,192,623.00 | 478,126,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 177,984,200.00 | 278,107,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,115,800.00 | 52,401,100.00 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 22,690,601.00 | 56,705,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 20,931,200.00 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,699,146.00 | 88,568,474.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 44,066,145.00 | 61,605,612.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5,183,295.00 | 7,419,021.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,146,636.00 | 3,772,094.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 861,334.00 | 2,764,842.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 10,441,736.00 | 13,006,905.00 |
| **2103** | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 30,093,853.00 | 43,774,500.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 8,140,458.00 | 11,848,853.51 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 19,644,533.00 | 28,208,791.49 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 2,308,862.00 | 3,716,855.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,054,700.00 | 6,920,183.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 881,050.00 | 2,736,760.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 889,750.00 | 976,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,283,900.00 | 2,678,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 528,223.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 44,200.00 | 549,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 44,200.00 | 549,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,867,800.00 | 20,844,775.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 829,000.00 | 7,229,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,038,800.00 | 12,514,875.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,059,488.00 | 24,534,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 34,917,788.00 | 22,433,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,141,700.00 | 2,101,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,884,030.00** | **44,390,368.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,999,800.00 | 21,532,804.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 11,191,404.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,999,800.00 | 10,341,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 13,884,230.00 | 22,857,564.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,884,230.00 | 22,857,564.00 |
| 7 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | - | 9,927,300.00 |
| 9 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 9,927,300.00 |
| 10 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 9,927,300.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | - | 9,927,300.00 |
| | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 9,927,300.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | - | -9,927,300.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 1,239,669,238.14 | 4,559,904,632.78 | -529,527,183.06 | 5,327,273,078.87 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,239,669,238.14 | 4,559,904,632.78 | -472,300,792.05 | 5,327,273,078.87 |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | - | -57,226,391.01 | -57,226,391.01 |
| 9 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,239,669,238.14 | 4,559,904,632.78 | -691,183,972.23 | 5,108,389,898.69 |
| 10 | 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 1,239,669,238.14 | 4,559,904,632.78 | -691,183,972.18 | 5,108,389,898.69 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,239,669,238.14 | 4,559,904,632.78 | -691,183,972.23 | 5,108,389,898.69 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | -104,840,379.20 | -104,840,379.20 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,239,669,238.14 | 4,559,904,632.78 | -796,024,351.43 | 5,003,549,519.49 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,083,582,900.00 | 1,067,037,436.00 | 16,545,464.00 | 98.47 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,083,582,900.00 | 1,067,037,436.00 | 16,545,464.00 | 98.47 |
| Бараа, үйлчилгээний зардал | 1,070,046,400.00 | 1,053,884,232.00 | 16,162,168.00 | 98.49 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 886,272,100.00 | 886,272,100.00 | - | 100.00 |
| Үндсэн цалин | 478,126,800.00 | 478,126,800.00 | - | 100.00 |
| Нэмэгдэл | 278,107,300.00 | 278,107,300.00 | - | 100.00 |
| Унаа, болон бусад нөхөн олговор | 52,401,100.00 | 52,401,100.00 | - | 100.00 |
| Урамшуулал | 56,705,700.00 | 56,705,700.00 | - | 100.00 |
| Гэрээт ажлын хөлс | 20,931,200.00 | 20,931,200.00 | - | 100.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 104,620,700.00 | 88,568,474.00 | 16,052,226.00 | 84.66 |
| Тэтгэврийн даатгал | 69,358,800.00 | 61,605,612.00 | 7,753,188.00 | 88.82 |
| Тэтгэмжийн даатгал | 9,099,900.00 | 7,419,021.00 | 1,680,879.00 | 81.53 |
| ҮОМШӨ-ний даатгал | 4,549,900.00 | 3,772,094.00 | 777,806.00 | 82.90 |
| Ажилгүйдлийн даатгал | 4,549,900.00 | 2,764,842.00 | 1,785,058.00 | 60.77 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Эрүүл мэндийн даатгал | 17,062,200.00 | 13,006,905.00 | 4,055,295.00 | 76.23 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 43,774,500.00 | 43,774,500.00 | - | 100.00 |
| Гэрэл цахилгаан | 11,234,900.00 | 11,848,853.51 | -613,953.51 | 105.46 |
| Түлш, халаалт | 28,353,300.00 | 28,208,791.49 | 144,508.51 | 99.49 |
| Цэвэр, бохир ус | 4,186,300.00 | 3,716,855.00 | 469,445.00 | 88.79 |
| Хангамж, бараа материалын зардал | 6,935,800.00 | 6,920,183.00 | 15,617.00 | 99.77 |
| Бичиг хэрэг | 3,252,800.00 | 2,736,760.00 | 516,040.00 | 84.14 |
| Тээвэр (шатахуун) | 608,700.00 | - | 608,700.00 | - |
| Шуудан  холбоо, интернэтийн төлбөр | 364,700.00 | 976,800.00 | -612,100.00 | 267.84 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,520,000.00 | 2,678,400.00 | -158,400.00 | 106.29 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 189,600.00 | 528,223.00 | -338,623.00 | 278.60 |
| Нормативд зардал | 549,400.00 | 549,400.00 | - | 100.00 |
| Нормын хувцас зөөлөн эдлэл | 549,400.00 | 549,400.00 | - | 100.00 |
| Эд хогшил худалдан авах | 17,541,100.00 | 17,466,975.00 | 74,125.00 | 99.58 |
| Багаж, техник, хэрэгсэл | 3,926,200.00 | 3,852,100.00 | 74,100.00 | 98.11 |
| Урсгал засвар | 13,614,900.00 | 13,614,875.00 | 25.00 | 100.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 10,352,800.00 | 10,332,600.00 | 20,200.00 | 99.80 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,423,400.00 | 1,403,200.00 | 20,200.00 | 98.58 |
| Даатгалын үйлчилгээ | 2,101,100.00 | 2,101,100.00 | - | 100.00 |
| Музейн үзмэр худалдан авах зардал | 6,828,300.00 | 6,828,300.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,536,500.00 | 13,153,204.00 | 383,296.00 | 97.17 |
| Бусад урсгал шилжүүлэг | 13,536,500.00 | 13,153,204.00 | 383,296.00 | 97.17 |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 11,574,700.00 | 11,191,404.00 | 383,296.00 | 96.69 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1,961,800.00 | 1,961,800.00 | - | 100.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,083,582,900.00 | 1,067,037,436.00 | 16,545,464.00 | 98.47 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,073,582,900.00 | 1,050,725,336.00 | 22,857,564.00 | 97.87 |
| Улсын төсвөөс санхүүжих | 1,073,582,900.00 | 1,050,725,336.00 | 22,857,564.00 | 97.87 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 10,000,000.00 | 16,312,100.00 | -6,312,100.00 | 163.12 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,000,000.00 | 15,994,100.00 | -5,994,100.00 | 159.94 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 318,000.00 | -318,000.00 | - |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 36 | 36 | - | 100.00 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 15 | 15 | - | 100.00 |
| Үйлчлэх ажилтан | 20 | 20 | - | 100.00 |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар 1,373.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 2 алдаанд залруулга хийсэн болно.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ХХОАТ-ын өглөгийг зөв тооцоолон, залруулан бүртгэв | 1 | 207.7 | | | | | 1 | 207.7 | | | | |
| Татварын өглөгийг тооцоо нийлж тулган баталгаажуулах | 1 | 1,165.9 | | | | | 1 | 1,165.9 | | | | |
| Дүн | 2 | 1,373.6 | | | | | 2 | 1,373.6 | | | | |

3.2 Аудитаар илэрсэн 1,135.8 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүллээ.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хөрөнгийн ангиллыг зөв тайлагнах | 1 | 1,135.8 | | | | | 1 | 1,135.8 | | | | |
| Дүн | 1 | 1,135.8 | | | | | 1 | 1,135.8 | | | | |

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Ахмадын санг илүү тооцоолон шилжүүлсэн | 1 | 40,788.1 | | | | | 1 | 40,788.1 |
| Нийт дүн | 1 | 40,788.1 | | | | | 1 | 40,788.1 |